ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 19 өдөр Дугаар А/202 Хужирт сум

Сумын Шуурхай штабыг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн "Шуурхай штаб байгуулах тухай" 8 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Шуурхай штабыг байгуулж ажиллуулсугай.

2. Шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга (Б.Дэмбэрэл)-д, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг холбогдох байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шуурхай штабт шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАТБАЯР

622301405
D:Alban bichig;Zahiramj 2023